



## ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

**Байгууллагын нэр:** ХААИС-ийн Магистр, докторын сургууль

**Хөтөлбөрийн нэр:** Агрономи

**Индекс:** 081109 доктор

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Оюунцэцэг (Ph.D)

Гишүүд: Б.Одгэрэл (Ph.D)

О.Энхтуяа (Ph.D)

Улаанбаатар хот

2023 он

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Докторын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Докторантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	ХААИС-ийн Магистр, докторын сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Агрономи	
<b>Индекс</b>	081109 доктор	
<b>Шинжээчид</b>	<p>Ахлагч:</p> <p>Б.Оюунцэцэг. Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны сургууль, Биологийн тэнхимийн багш, доктор, профессор</p> <p>Гишүүд:</p> <p>Б.Одгэрэл- Отгонтэнгэр их сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, доктор</p> <p>О.Энхтуяа- Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор</p>	
<b>БМИҮЗ-ийн зохицуулагч</b>	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунчимэг	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.12.08	Шинжээчийн багтай гэрээ байгуулах
	2022.12.08	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хүлээн авах
	2022.12.16	Өөрийн үнэлгээний тайланг уншиж судлан дүгнэлт хийх, тодруулах асуудал бүхий урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид илгээх
	2022.12.20, 21	Шинжээчийн баг сургууль дээр ажиллах
	2022.12.30	Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлт, тайланг илгээх.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Докторын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1.1.Хөтөлбөрийн нэр: “Агрономи”, Англиар “Agronomy”

1.2.Индекс: F08110101

1.3. Агрономи мэргэжлийн докторын хөтөлбөр нь Монгол улсын БСШУ-ны Сайдын 2014 оны “Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, батлах, журамд өөрчлөлт оруулах тухай”, А/370 тоот тушаалын дагуу Хөдөө аж ахуй гэсэн мэргэжлийн чиглэлд багтдаг биеэ даасан хөтөлбөр юм.

Монгол Улсад дээд боловсролын системд олон улсын жишгийг дагаж их, дээд сургуулиудын мэргэжлийн хөтөлбөрүүд бүхэлдээ шаталсан сургалтад шилжиж эхэлсэнтэй холбоотойгоор Агрономийн хөтөлбөр ч 1993 оноос шаталсан сургалт явуулж докторын хөтөлбөрөөр элсэлт авч эхэлсэн.

1993-2020 онд агрономич мэргэжлээр 109 доктор төгсөж, Монгол улсын Газар тариалангийн шинжлэх ухаан-сургалт-үйлдвэрлэлийн салбарт амжилттай ажиллаж байна.

Агрономи мэргэжлийн докторын сургалтын төлөвлөгөө нь Агроэкологийн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлцэгдэж, ХААИС-ийн захирлын 2022.02.07-ний өдрийн тушаалаар батлагдсан.

### **Хөтөлбөрийн зорилго**

Агрономийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлага, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх боломж, арга замуудыг шинжлэх ухааны үндэстэйгээр тогтоох, тодорхой асуудал шийдвэрлэх арга зүйг боловсруулан туршилт судалгааны ажил гүйцэтгэж үр дүнг бүтээлийн хэмжээнд боловсруулан мэргэжлийн түвшинд хэлэлцүүлэх, хэвлэн нийтлүүлэх чадвар бүхий мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд оршино.

**Хамрах хүрээ:** Газар тариалан, ургамлын аж ахуй

**Хөтөлбөр боловсруулах үндэслэл:**

Нийгмийн ардчилсан өөрчлөлтийг дагаад улс орны боловсрол тэр тусмаа дээд боловсролын системд олон улсын жишгийг дагах, түүнд аажмаар нийцүүлэх (кредит систем) үндсэн өөрчлөлт оруулсан шинэчлэл явагдаж ирлээ. Их, дээд сургуулиудын мэргэжлийн хөтөлбөрүүд бүхэлдээ шаталсан сургалтад шилжив. Иймээс 1993 оноос эхлэн Агрономийн хөтөлбөрийг шаталсан сургалтанд шилжүүлж сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан сайжруулж ирсэн.

Тус хөтөлбөрийг шаталсан сургалтад шилжүүлэн докторын сургалт явуулж эхэлснээс хойш суралцагчид нь улс орныхоо газар тариалан, ургамлын аж ахуй салбарт тулгамдаж буй асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдэж ирлээ. Тухайн хөтөлбөрөөр суралцан төгсөгчид нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн үндэний хөтөлбөрүүд болон хөгжлийн бодлогын томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцон ажиллаж байна. Агрономийн докторын хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримтлан, сургалтанд оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан.

### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

#### **Шалгуур 1. ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, АГУУЛГА**

Үндэсний хөгжлийн стратеги, сургуулийн судалгаа ба хөгжлийн стратеги, мэргэжлийн салбарын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна.

##### **1.1. Хөтөлбөрийн боловсруулалт**

Дээд боловсролын хууль эрх зүй, докторын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Докторантын гүйцэтгэх судалгаа, хөгжил, бүтээлч ажлууд нь хөтөлбөрт дийлэнх хувийг эзлэх ба тэдгээрийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалт, үр дүнг хүлээн зөвшөөрөх арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжин, чанартай судалгаа хийхэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

1. “Хаан кампус” хөтөлбөр 2010 он
2. ХААИС-ийн докторантын сургалтын гарын авлага 2015 он.
3. ХААИС-ийн сургалтын хурмыг шинэчлэн батлах тухай журам А/194, 2022.07.05
4. Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм А/92, 2021.03.12
5. Магистр докторын сургалт эрхлэх нийтлэг журам А/370, 2014.09.12
6. ХААИС-ийн магистрант, докторантын эрдэм шинжилгээ, дадлагын багц цаг тооцоход баримтлах журам А/194,2022.07.05
7. Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам А/194,2022.07.05

8. Докторын хөтөлбөр нь Агрономи 08110101, Тарималын селекци үрийн аж ахуйн агрономи 08110102, Жимс ногооны аж ахуйн агрономи 08180101 зэрэг мэргэжлийн хөтөлбөр

#### **Онцлог зүйл:**

- "Агрономи" мэргэжлийн анги 1955 онд нээгдэж байсан бол 1958 оноос агрономын хөтөлбөрөөр сургалт явагдаж эхэлсэн.
- Хөтөлбөрийн зорилго, агуулга, ач холбогдол өндөр. Монгол орны эдийн засгийн тэргүүлэх салбар, ХАА-г хөгжүүлэх шинэ сэргэлтийн бодлогын хүнсний бүтээгдхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах чухал хөтөлбөр юм.
- 1993-2020 онд Агрономи мэргэжлийн чиглэлээр 109 доктор төгсөж, газар тариалангийн шинжлэх ухаан- сургалт үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.
- 2006 онд докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулагдсан.
- Төгсөгчдөөс сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулах, шинэ хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлох зорилгоор судалгаа, санал асуулга авч, дүгнэлт хийдэг. Сургууль, багш, төгсөгчид эргэх холбоотой байна.
- Тэргүүлэх чиглэл, эрэлт хэрэгцээтэй.
- Туршлага, практик, хээрийн судалгаа, дадлагад суурилсан баазтай

#### **Анхаарах асуудал:**

1. Хөтөлбөрийн лекц, семинарын хувиарлалт бүрхэг, тайлан, хөтөлбөрт ялгаатай тусгасан.
2. Сүүлийн 5 жилд хэрхэн боловсруулалт хийж сайжруулсан мэдээлэл байхгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Орчин үеийн онцлог, хэрэгцээ шаардлагыг тусган хөтөлбөрийн боловсруулалтыг сайжруулах,
- Молекул биологи, орчин үеийн судалгааны арга зүй чиглэлийн хичээл оруулах
- Ухаалаг газар тариалангийн хичээл оруулах
- Ургамлын селекци Монгол улын тариалангийн сэлгээнд шийрэг ургамлууд орж байна. Шинэ ургамлуудтай холбоотой судалгааны ажилыг эхлүүлэх хэрэгтэй

#### **Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн төгсгөлд докторантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь тухайн шинжлэх ухааны чиглэл, улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн стратеги, сургуулийн судалгааны зорилгод нийцсэн (сургуулийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Агрономи хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө
- Эрхэм зорилгын харьцуулал
- Үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөр

**Онцлог зүйл:**

- Монгол Улсын тэргүүлэх чиглэл, ХААИС эрхэм зорилго зэрэгтэй нийцсэн. Хөтөлбөр тодорхой түүхэн хөгжлийн явцад хөгжсөн, дүрэм журмын тодорхой нийтлэг шаардлага хангасан, онол практик хосолсон, илүү хээрийн туршилт судалгаанд суурилсан онцлогтой.

**Анхаарах асуудал:**

- Судалгааны ёс зүй, оюуны өмчийн талаар докторантад хүрч байгаа мэдлэг, хөтөлбөрөөр олгодог хичээл байхгүй.

**Зөвлөмж:**

- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарах, тогтвортой сайжруулах.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан**1.3. Хөтөлбөрийн агуулга**

Хөтөлбөрийн агуулга нь шинжлэх ухааны чиглэл, суралцахуйн зорилтот үр дүнд нийцсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн болон салбар дундын судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хорооны хурлын үр дүнгээр 2021 онд хөтөлбөрийг сайжруулсан. Уялдаа холбоог сайжруулсан. 2021.11.02 ХААИС хөтөлбөрийн хороо өөрчлөгдсөн.
- Тухайн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан 2019 оны хувилбараар мэргэжлийн суурь хичээл 12 багц, мэргэжүүлэх хичээл 21 багц, судалгааны семинар 6 багц байхаар тусгаж, судалгааны семинарт 3-4 удаа оролцоход суралцагчдад үнэлгээ тавьж байхаар боловсруулсан. Ингэснээр мэргэжлийн суурь, мэргэжүүлэх хичээл, судалгааны семинар, докторын ажлын харьцааг 19:33.3:9.5:38 гэсэн харьцаатай болгож өөрчилсөн.
- ХААИС-ийн Магистр, докторын сургалтын журамын 3.4.5-аар зохицуулдаг.
- Хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны тухай ХААИС Магистр, докторын сургалтын журам 2014.11.14 А/898-ын 3.2-оор зохицуулсан. 2017, 2019 онуудад бага зэрэг өөрчлөлт хийж одоогоор мөрдөж байгаа.
- Агроэкологийн сургуулийн магистрант, докторантын судалгааны семинарын урилга, хөтөлбөр, хэлэлцэгдсэн материал.

**Онцлог зүйл:**

- Докторын хөтөлбөрийг Монгол Улсын ХАА-н салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх, өөрийн орны болон гадны улс орнуудын ижил мэргэжлийн чиглэлийн судлаачтай хамтран ажиллах, олон улсад хөврөх чадвартай мэргэжилтэн бэлдэх чиглэл дээр суурилан сургалтаа явуулдаг.
- Докторант удирдагчаа багшаа сонгож, мэргэжлийн хөтөлбөрийн дагуу туршилтын тоон боловсруулатын шинжилгээ, судалгааны арга зүй боловсруулах, судалгааны ажлын хээрийн туршилт тавих ажлыг 3 жилд багтаан хийдэг.
- Хөтөлбөрийн үр дүнд төгсөгчдийн ур чадваруудыг ажил олгогч болон хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн.

**Зөвлөмж:**

- Докторантын эрдэм шинжилгээний ажлыг багц цагийн үнэлгээтэй болгох
- Сургалтын орчин, материаллаг баазыг (тоног төхөөрөмж) сайжруулах, орчин үеийн судалгааны арга зүй болон сурах бичиг (мэргэжлийн)-ийг сургалтад ашиглах
- Хөтөлбөрийн агуулгыг оролцогч талуудын санал хүсэлтийг тусган тогтмол сайжруулах

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **1.4. Хичээлийн хөтөлбөрүүд**

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, докторантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Эдгээрийг байнга сайжруулахын зэрэгцээ тухай бүр суралцагчдад ил тод мэдээлдэг байна. Докторант нь манлайлах, багшлах, олон улсын багт ажиллахад шаардагдах ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн хөтөлбөр МДС-ийн захирлаар батлагдсан. АЗ70 Нийтлэг шаардлагын дагуу боловсруулагдсан.
- Хичээл тус бүрийн иж бүрэн материалыг цаасаар болон цахимаар боловсруулсан хавтас бүхий баримт бичиг
- Үнэлгээний аргачлал
- Докторантын судалгааны ажил, семинар хэлэлцүүлэх журам
- Хичээлийн дадлага ажлын тайлан
- Судалгааны ажлын хэлэлцүүлгийн материал
- Шалгалтын материал
- Сурах бичиг, ашиглах бүтээлийн жагсаалт
- Төслийн баг томилсон болон докторант ажиллуулсан тушаал
- Төслийн үр дүн тайлан

**Онцлог зүйл:**

- Суралцахуйн үнэлгээ нь дүрэм, журамтай, тодорхой санхүүжилттэй судалгааны төсөл, хөтөлбөрт докторант оролцох боломжтой.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөр боловсруулахдаа оюутанд олгох мэдлэг чадвар дадлыг хичээл бүр, сэдэв бүрээр алхамчлан дэлгэрэнгүй болгон боловсруулах.
- Судалгааны арга зүйг жил бүр сүүлийн үеийн дэвшилтэт арга зүйгээр баяжуулан боловсруулдаг байх.
- Шинэчлэх, шинэ хэрэгцээ шаардлагатай олон улсын түвшинд нийтлэг сурах бичиг гарын авлагаар хөтөлбөрийг баяжуулах
- Англи сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан



### **1.5. Хөтөлбөрт тавих тусгай шаардлага**

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлага (Зальцбургийн зарчим гэх мэт)-ыг хангахыг эрмэлзэнэ..

#### **Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн зөвлөлөөс энэхүү хөтөлбөрт тусгай шаардлага тавьдаггүй. ХААИС-ийн сургалтын журмыг 2022 оны 07-р сарын 05-ны өдрийн захирлын А/ 194 тушаалаар шинэчлэн баталсан.
- Сургалтын төлөвлөгөөг өндөр хөгжилтэй гадаад улс, мөн Монголын бусад их дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөтэй харьцуулж үзэх замаар сайжруулдаг.

#### **Онцлог зүйл:**

- Сургалтын төлөвгөөний шинэчлэл, өөрчлөлтийг тухайн цаг үеийн нийгмийн хөгжил, ажлын байрны хэрэгцээ шаардлага, төгсөгч, ажил олгогчдын хүсэл, сонирхол ажлын байрны ур чадварын хэрэгцээг баримтлан хийдэг.

#### **Зөвлөмж:**

- Хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөрийн харьцуулсан судалгааг өргөжүүлэх, сайжруулах
- Сургалт, судалгааны лабораторын нөхцөл байдал дадлагын хичээлийг техникжүүлэх
- Судалгааны дата мэдээлэлийн сантай болох

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## **Шалгуур 2. ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ**

**Докторын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, докторантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.**

### **2.1 Элсэлт**

Элсэгчид тавих шаардлага нь докторын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцөлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOEFL, IELTSг.м) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтын хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Элсэлтийн зар, элсэлтийн тушаал жил бүрээр
- Элсэлтийн комисс томилсон тушаал
- Элсэгчийн шалгалтын материал
- Англи хэлний шалгалтын үнэлгээ, дүн /2020 намар, хавар/
- Бусад мэргэжлээс элсэгчдийн нэмэлт багц баталсан, тооцсон сонгосон ганцаарчилсан төлөвлөгөө
- Бусад мэргэжлээс элсэгчдийн нэмэлт багц санал болгох жагсаалтыг хэлэлцсэн хөтөлбөрийн дэд хорооны тэмдэглэл
- Докторантуудын судалгааны арга зүй хэлэлцсэн тэмдэглэл (2021.06.08, 2019.05.10, 2019.06.11 өдрүүдийн)
- Удирдагчаар ажиллах зөвшөөрлийн хуудас жил бүр МДС
- Сэдэв удирдагч баталсан тушаал 2017.06.15, 2019.04.24, 2021.01.18 өдрийн тушаалууд,
- Элссэн оюутантай байгуулсан гэрээ
- Магистрантур, докторантурт суралцах сургалтын гэрээ
- Магистрантур, докторантурт элсэн суралцагчаас элсэлтийн шалгалт авах, хичээл заах багш нарыг томилох тухай 2022.09.20 №21, тушаалын 1-р хавсралт
- 2022.07.05 А/194 ХААИС-ийн сургалтын журам шинэчлэн батлах тухай А/194 4.2.2 Элсэлтийн асуудлыг тусгаж өгсөн. Нөхөн судлах бусад багцыг хөтөлбөрийн хороо тогтоохоор заасан ч сүүлийн 5 жилд өөр мэргэжлээс орж ирсэн докторант байхгүй

#### **Зөвлөмж:**

- Гадаад хэлний шалгалтыг олон улсын оноотой дүйцүүлэх зохицуулалт журамлагдаагүй байгааг дүйцүүлэх
- Элсэлтийн мэргэжлийн сурталчилгааг нэмэгдүүлэх, сурталчлах
- Өөр мэргэжлээс элсэн суралцагчдын нэмэлт багц цагийн хөтөлбөрийг МДС дүйцүүлдэг байгааг мэргэжлийн багц хөтөлбөрийг боловсруулан хөтөлбөрийн хороогоор батлуулан мөрдөж ажиллах

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

### **2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг**

Докторантын сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлын ачаалал нь улирал бүрд жигд, зохистой хэрэгжиж, хэт ихсэх болон багасахаас сэргийлж, докторантын суралцах хугацаа

хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхээр төлөвлөж, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэлэлцэн батлах тогтолцоотой.
- ХААИС-ийн Хөтөлбөрийн хорооны журам 2015.11.04
- Хөтөлбөрийн ерөнхий хороо, Мэргэжлийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл
- Агрономи хөтөлбөрийн магистр, докторын сургалт хариуцсан хөтөлбөрийн хорооны тайлан 2015
- Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам
- Сургалтын төлөвлөгөө 2015,2017
- Сургалтын төлөвлөгөөний дагуу боловсруулсан хичээлийн хөтөлбөр
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө
- Нийтлэг шаардлагын дагуу Хөтөлбөрт тусгагдсан хичээлийн багц цагийн харьцааг тогтоосон
- Улирал бүр суралцах кр хэмжээ зохистой тогтоосон

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй**

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, докторантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмжих ба судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Төсөлд суурилсан,орчинд суурилсан, асуудалд суурилсан арга зүйг ашигладаг.
- Докторантыг төсөлд суурилсан сургалтад оролцуулсан тухай-Төслийн баг байгуулах тухай захирлын 2022.04.14 өдрийн А66 тушаал, НҮБ-ийн “Монгол оронд Агро экологийн зарчим, ШУ-ны үндэслэлийг боловсруулан хөгжүүлэх төсөл”
- Төслийн судалгааны баг батлах тухай захирлын 2022.09.02 А139 дугаар тушаал
- Гэрээт судалгааны ажлын баг байгуулах тухай 2020.06.29 А63
- Гэрээт судалгааны ажлын баг байгуулах тухай 2020.06.29 А62
- Төслийн баг батлах тухай 2020.04.13 А28
- Төслийн баг батлах тухай 2021.05.19 А 38
- Орчинд суурилсан сургалтыг гурван түшиц бааз, туршилтын талбайд хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийн онцлогт тохирсон лабораторитой. Сүүлийн 2 жилд олон улсын хамтарсан төсөл хөтөлбөрөөр шинэчлэгдсэн орчин үеийн үрийн лабораторийг шинээр нээсэн.
- Докторант оюутнуудын семинарын удирдамж жил бүрээр
- Удирдагч багшаас туршилт судалгаанд суурилсан шинжтэйгээр судлаачийн ёс зүйн асуудлыг тусгаж байна. Удирдагч багшийн үүрэг, чиглэлийн гаргаж байна
- Оюутны хөгжлийн хөтөлбөр
- Докторантын гарын авлагаар шаардлагатай мэдээллийг хүргэж ажилладаг.
- Туршилтад ан амьтан хэрэглэх ёс зүйн журамтай. 2016 оны А142 тоот тушаалаар батлагдсан
- Туршилтад ан амьтан хэрэглэх ёс зүйн хяналтын зөвлөлийн ажиллах журамтай. 2016 оны А142 тоот тушаалаар батлагдсан

### **Онцлог зүйл:**

- Хээрийн судалгаа, туршилтын талбайн судалгаанд докторантын оролцоо сайн, төсөлд докторантын оролцоо сайн.

### **Зөвлөмж:**

- Суралцагчийн судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, оюуны өмчийн асуудлаар богино хугацааны семинар зохион байгуулах, кр бус агуулгаар төлөвлөгөөнд тусгах

### **Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **2.4 Судалгааны ажил**

Докторант, удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу докторантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлэх үйл явцыг тодорхойлсон байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвартай байна..

### **Илрэл нотолгоо:**

- Докторантын ганцаарчилсан төлөвлөгөө
- Судалгааны ажлын семинар
- Докторантын хамгаалалтын өмнө бүрдүүлэх материалын бүрдэл хавтас
- Судалгааны ажлын лабораторийн тодорхойлолт
- Агроэкологийн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын хэлэлцүүлгийн материал
- Багш нарын онолын семинар явуулах батлагдсан хуваарь
- Агроэкологийн сургуулийн магистрант, докторантын судалгааны семинарын материалууд
- Судалгааны ажлын хүрээнд авсан сортын тодорхойлолтууд
- Судалгааны ажил хэлэлцсэн тухай тэнхмийн хурлын протоколууд
- Профессорын багийн хурлын тэмдэглэл
- Докторантын бүтээлийн жагсаалтууд
- Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд илгээсэн Агроэкологийн сургуулийн албан бичиг, тодорхойлолтууд
- Урьдчилсан хамгаалалтын тэмдэглэл
- Эрдэм шинжилгээний ажлын удирдагчийн тодорхойлолт
- Эрдэм шинжилгээний шүүмж
- Эрдэм шинжилгээний хурал
- Агрономи хөтөлбөрийн магистр, докторын сургалт хариуцсан хөтөлбөрийн хорооны тайлан 2015.11.20
- Докторантуудын ганцаарчилсан төлөвлөгөө-докторант бүрээр
- Бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл-арга зүй-удирдагч томилох
- Удирдагчийн докторант удирдах лемит байхгүй,
- Удирдагч МДС-д санал гомдол гаргана (Хуудас)

### **Онцлог зүйл:**

- 3 жилийн туршилт судалгааг семинараар хэлэлцэж хамгаалалтад оруулдаг.
- Докторант гадаадын өндөр зэрэглэлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлдэг.

### **Анхаарах асуудал:**

- Судалгааны ажлын удирдагчийг үнэлэх тогтолцоо байхгүй, удирдагчийг суралцагч үнэлэх тогтолцоогүй.

### **Зөвлөмж:**

- Удирдагч багшийг суралцагч үнэлэх хуудас, удирдагч докторантыг үнэлэх хуудсаар жил бүр тогтмол явцын болон зөвлөн туслах ажлын тайланг гаргаж үнэлгээ хийж байх.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

### **2.5 Бүтээлч ажил**

Докторант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцож, судалгааны бүтээлээ хэвлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Докторантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

### **Илрэл нотолгоо:**

- Багш нар болон докторантуудад зориулсан онолын болон судалгааны семинарын хөтөлбөр, урилга
- Эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн олон улсын хурал, тариаланчдын зөвлөгөөн зохион байгуулсан материалууд
- Бордооны хэрэглээ ба үйлдвэрлэл, хөрс хамгааллын буурцагтан ба модлог ургамлын ач холбогдол ОУЭШХ
- Бусад эрдэм шинжилгээний хурал болон материалууд

### **Онцлог зүйл:**

- Судлаач оюутны тэтгэлэг грант олгох журамтай.
- Туршилтын талбай, лабораториуд докторантуудад нээлттэй, үнэ төлбөргүй

### **Зөвлөмж:**

- Оюутны эрдэм шинжилгээний бүтээлүүдийг үнэлэх баталгаажуулах кр тогтолцоотой болох.
- МДС-аас Судалгааны ёс зүй, оюутны өмч, флажеризмийн тухай кредит тооцдоггүй боловч докторантыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулж хэвших.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 3. ДОКТОРАНТЫН СУРАЛЦАХУЙН ҮНЭЛГЭЭ, ХӨГЖИЛ**

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний систем, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт**

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-ийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулахад чиглэсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Докторантын нэгдсэн шалгалтын баг байгуулах тухай ХААИС-ийн МДС-ийн захирлын тушаалууд
- Батлагдсан хичээлийн стандартууд
- Хичээлийн үнэлгээн хичээл бүрээр
- Багш нарын хичээлийн багц
- Багш нарын бүрдүүлсэн шалгалтын материалууд
- Туршилт дадлагын ажлуудын эмхэтгэл 2017
- Багшийн цахим журнал
- Өндөр зэрэглэлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх нь докторантын хамгаалалтын өмнө бүрдүүлэх материалын жагсаалтад тусгасан.
- Батлагдсан хөтөлбөрүүдийн үнэлгээний хэсэг
- ХААИС-ийн сургалтын журам (2022.07.05) 6.4-т магистр докторын сургалтын үнэлгээ хэсгийг тусгаж өгсөн
- Нэгдсэн шалгалтын комисс томилсон тушаал
  
- Шалгалт, хичээлийн хуваарь

#### **Онцлог зүйл:**

Туршилт судалгаа, Төслийн үр дүнгээр хичээлийн үнэлгээг тооцдог тогтолцоотой.

#### **Зөвлөмж:**

- Туршилт, судалгааг үнэлгээнд тооцож байгаа боловч шалгалтын арга зүй дийлэнхдээ хуучинсаг хэлбэртэй (тест) байгааг анхаарч хөтөлбөрийн хороод шинэлэг арга зүйн туршлагауудыг түгээн дэлгэрүүлэх, үнэлгээний арга зүйг шинэчлэх

#### **Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **3.2. Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх**

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцох журамтай байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэхийг эрмэлзэнэ.

#### **Илрэл нотолгоо:**

- Журам дүйцүүлэлтийн хүснэгттэй

- Бусад байгууллага, нэгжээс сонгох хичээлтэй
- Англи хэлний шалгалтыг дүйцүүлэх тогтолцоотой
- ХААИС-ийн сургалтын журам 2022.07.05 -ын 9 хэсэгт хичээл дүйцүүлэлтийн болон шилжилт хөдөлгөөний тухай тусгай бүлэг тусгасан.
- Хичээл дүйцүүлэх өргөдлийн маягттай

#### **Анхаарах асуудал:**

- ХААИС-ийн сургалтын журам 2022.07.05 -ын 9 хэсэгт хичээл дүйцүүлэлтийн тухай тусгай бүлэг 9.2.9 “Гадаад хэлний шалгалтын оноогоор докторын түвшний хичээл дүйцүүлэхгүй” гэсэн нь гадаад хэлний шалгалтын оноог дүйцүүлж байсан өмнөх журмаас ухралт хийсэн мэт

#### **Зөвлөмж:**

- Англи хэлний шалгалтыг орчин үеийн дүйцүүлэлтэд чиглүүлэх
- Оюутан солилцооны зохицуулалтыг оруулах, солилцооны хөтөлбөртэй болох

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **3.3. Суралцагчийг дэмжих, зөвлөх үйлчилгээ**

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлэх нөөцийг бүрдүүлсэн байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээт гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх сургалтын орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн байна. Докторантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Ганцаарчилсан төлөвлөгөө гаргахад хөтөлбөрийн хорооны зохицуулагч зөвлөн ажилладаг
- Докторантуудад зориулсан гарын авлагатай
- Туршилт судалгаанд дэмжлэг үзүүлдэг
- “Мэдлэгээ хуваалцаж” эрдэм шинжилгээ судалгааны семинарыг уламжлал болгон зохион байгуулдаг
- Хамтарсан төсөл хөтөлбөрт оролцох боломжтой
- Докторантын шилдэг бүтээлд грант олгох тогтолцоотой
- 2022 онд батлагдсан сургалтын журмын 7-р бүлэгт суралцагчдад тэтгэлэг урамшуулал олгох асуудлыг тусгайлан оруулсан
- Оюутны дотуур байр ашиглах журам
- Оюутын хөгжлийн хөтөлбөр
- Аргономийн докторын хөтөлбөрийн хөгжлийн хөтөлбөр 2021.10.03

#### **Анхаарах асуудал:**

- Санал гомдол авах тогтолцоо нээлттэй биш, докторантууд санал гомдол гаргах журам, дүрмийн тодорхой ойлголтуудгүй.

#### **Зөвлөмж:**

- Докторантуудын хөгжлийн хөтөлбөрийг ажлын төлөвлөгөө шинжтэй байгааг илүү бодлогын шинжтэй боловсруулан хөгжүүлэх, хөтөлбөрийг үнэлэх

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### 3.4. Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, докторантын судалгааны ажлыг олон эх үүсвэрээс санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журамтай байна.

#### Илрэл нотолгоо:

- Профессорын баг ажиллах журмын 5.2-т Профессорын багт ЭШ ажлын төсвөөс 10 хувийг олгох тухай тусгасан.
- ХААИС-аас судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ 2019.01.18
- ХААИС-иас судалгааны төсөл санхүүжүүлэх журам
- ХААИС-ийн 2019 оны төсөвт 3.9 хувийг ЭШ, судалгааны ажил, төсөл, ШУТсан гэж хуваарилсан.

#### Анхаарах асуудал:

- Судалгааны санхүүжилт, гадны эх үүсвэрээс орж буй санхүүжилтийн хөтөлбөрт орж буй хувь хэмжээ тодорхой бус
- Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, ажлаас санхүүжилт тус хөтөлбөр болон докторантын судалгааны ажилд зарцуулагдаж байгаа эсэх тухай мэдээлэл өөрийн үнэлгээний тайланд тусаагүй.

#### Зөвлөмж:

- Өртөгт суурилсан хөтөлбөрийн үнэлгээг хийж, хөтөлбөрийн стратегийн бодлого зорилгод тусгах

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### 3.5. Тэтгэлэг, тэтгэмж

Докторантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журамтай байхын зэрэгцээ түр болон байнгын ажлын байраар хангах боломжийг судалсан байна.

#### Илрэл нотолгоо:

- Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журам
- Докторантуудын грант авсан тухай мэдээлэл
- ХААИС-ийн сургалтын журам (2022.07.05) 7-д Тэтгэлэг, урамшууллын тогтолцоог тусгасан.
- Профессорын баг ажиллах журмын 5.4-т Профессорын багт ажилласан докторантын төлбөрийн 25 хувийг эдлэх боломжтой тухай тусгасан.
- Агрономи хөтөлбөрт суралцаж байгаа ХААИС багшид 30-50 хувийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгодог.
- ХААИС-ийн захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээ 2021.12.21

#### Зөвлөмж:

- Гадаад дотоод оюутнуудаас сургалтын төлбөрийн талаар сэтгэл ханамжийн харьцуулсан судалгааг хөтөлбөр болон МДС авч дүгнэн, үйл ажиллагаандаа тусгах

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан



### **3.6. Судалгааны баг, хамтын ажиллагаа**

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын дотоодын болон гаднын судалгааны нэгж, байгууллагуудтай холбоо тогтоож, түншлэх, багш, докторантууд судалгааны багт оролцох боломж нөхцөлийг тандан судалж, зарим ажлыг эхлүүлсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Профессорын багийн ажиллах журам
- Профессорын багийн үйл ажиллагааг дэмжих тухай захирлын А/39 тушаалаар (2015.05.12) багшид 2,512,500 төг дэмжлэг үзүүлсэн /Эмийн ашигт ургамлыг тарималжуулах/
- Профессорын багийн бүрэлдэхүүн томилсон тухай тушаал
- Судалгааны төсөл сонгох шалгаруулах, санхүүжүүлэх журам
- ШУ-ны оны шилдэг ажил шалгаруулах журам
- Магистр, докторын судалгааны тэтгэлэг олгох журам
- ЭШ, судалгаа, хөгжлийн ажил, дүрэм журмын эмхэтгэл
- Профессорын багууд хоорондын хамтын ажиллагааны гэрээ “Хөрсний үржил шим ба тогтвортой газар тариалангийн хөгжил” 2017.10.20 ба бусад
- Хувийн аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ “Гарааны монгол экологийн бордоо” ХХК профессорын багийн хамтын ажиллагааны гэрээ 2017 ба бусад
- Зөвлөх үйлчилгээний баг байгуулах тухай захирлын тушаал 2020.10.06 А 87
- Төсөл шалгаруулах комисс, ХААИС эрдмийн зөвлөлөөр төсөл шалгаруулах процесс

#### **Онцлог зүйл:**

- Профессорын багийг дэмжих удирдлагын дэмжлэгтэй.
- Гадаад хамтын ажиллагааны төслүүдийг тоо нэмэгдэж байна.
- Хамтарсан өндөр түвшний лаб байгуулсан докторантуудыг төсөлд хамруулдаг

#### **Зөвлөмж:**

- Гадаад хамтын ажиллагаанд солилцооны хөтөлбөрийг нэмэгдүүлэх

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **3.7. Диссертац хамгаалах**

Диссертац хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгууруудыг боловсруулсан байна. Диссертац хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.)-ийг докторант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар тодорхойлсон байна

#### **Илрэл нотолгоо:**

- Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм
- Хамгаалалтын баримт бичиг
- Доктор хамгаалсан төгсөгчдийн хамгаалалтын өмнө бүрдүүлсэн баримт бичгийн хавтас
- Докторантын ганцаарчилсан төлөвлөгөө
- Судалгааны ажлын семинар

- Докторантын хамгаалалтын өмнө бүрдүүлэх материалын бүрдэл хавтас
- Судалгааны ажлын лабораторийн тодорхойлолт
- Агроэкологийн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын хэлэлцүүлгийн материал
- Багш нарын онолын семинар явуулах батлагдсан хуваарь
- Агроэкологийн сургуулийн магистрант, докторантын судалгааны семинарын материалууд
- Судалгааны ажлын хүрээнд авсан сортын тодорхойлолтууд
- Судалгааны ажил хэлэлцсэн тухай тэнхмийн хурлын протоколууд
- Профессорын багийн хурлын тэмдэглэл
- Докторантын бүтээлийн жагсаалтууд
- Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд илгээсэн Агроэкологийн сургуулийн албан бичиг, тодорхойлолтууд
- Урьдчилсан хамгаалалтын тэмдэглэл
- Эрдэм шинжилгээний ажлын удирдагчийн тодорхойлолт
- Эрдэм шинжилгээний шүүмж
- Эрдэм шинжилгээний хурал
- Агрономи хөтөлбөрийн магистр, докторын сургалт хариуцсан хөтөлбөрийн хорооны тайлан 2015.11.20
- Докторантуудын ганцаарчилсан төлөвлөгөө-докторант бүрээр
- Бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл-арга зүй-удирдагч томилох

#### **Онцлог зүйл:**

- Мэргэжлийн хүрээлэн, ажил олгогчдоос судалгааны сэдвийн санал авдаг.
- Судалгааны чиглэл сэдвийн санал авдаг нь эрэлт хэрэгцээтэй судалгааг нэмэгдүүлж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

### **3.8. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөгчид, суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Дээд боловсролын диплом олгох журам
- Боловсролын баримт бичгийн загварыг шинэчлэн батлах тухай
- ХААИС Докторын диплом
- ХААИС Докторын дипломын хавсралт
- Докторын диплом авахад шаардлагатай баримт бичгийн бүрдүүлэлтийн агсаалт

#### **Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Шалгуур 4. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН**

Докторын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

##### **4.1. Багшийн нөөц**

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Багшийн гарын авлага
- Багшийн веб
- Багшийн ажлын журам дүрэм
- Багшлах боловсон хүчний судалгаа
- Багш нарын сүүлийн 5 жилийн бүтээлийн жагсаалт хүснэгт (Багш бүрээр)
- Хөтөлбөрт хичээл заах багшийн шалгаруулалт, шаардлага нь ХААИС-ийн захирлын 2017 оны 04 сарын 20-ны өдрийн А/86 тоот тушаалын дагуу гарсан ХААИС-ийн профессор багш ажиллуулах журмаар зохицуулагддаг.
- “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-д нийцүүлэн багшийг сонгож, хүний нөөцөө бүрдүүлэн ажилладаг.
- Хөтөлбөрт орох хичээлүүд болон багшлах бүрэлдэхүүнийг сонгохдоо хөтөлбөрийн хороогоор хэлэлцэх ба хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг Эрдмийн зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн сургуулийн захиралын тушаал гарна.
- Докторын судалгааны ажлын удирдагч нь өөрийн тэнхим, профессорын баг, лабораторийн түвшинд болон бусад нэгжтэй хамтарсан байдлаар докторантын туршилт, судалгааны ажлын арга зүй, үр дүн бие даалтын ажлын явц зэргийг хуваарийн дагуу тогтмол хэлэлцүүлж, судалгааны семинар зохион байгуулдаг байна гэсний дагуу багшийн сонголтыг хийж УХХЦХҮ-ний магистрын хөтөлбөрт хичээл заах багш нарын бүртгэлд 13-15 багш бүртгэлтэй байна

##### **Онцлог зүйл:**

- Шинжлэх ухаан, үйлдвэрлэл практикийн болон ахисан түвшний сургалт, судалгааны ажлын туршлагатай, мэргэшсэн багш нар ажилладаг. 2022 онд доктор 16, ШУ-ны доктор 2, дэд профессор 12, профессор 3.
- Судалгааны ажлын удирдагч нь докторын зэрэгтэй, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай. Докторын хөтөлбөрт тус сургуулийн болон эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн багш, судлаач нар 10-12 мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийг тэнхимийн болон хээрийн сургалт судалгааны төвүүдэд ордог байна.
- Нийт хичээл ордог багш нар 100% доктор зэрэгтэй, 90% нь профессор, дэд профессор зэрэгтэй, ургамал хамгааллын агрономч, ургамал хамгаалал хорио

цээрийн хяналт үнэлгээ, агрономч, хөрс судлаач, молекул биологи, микробиологийн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн багш нар хичээл зааж байна.

- Тухайн хөтөлбөрийн докторын хөтөлбөрт хичээл заадаг багш нар нь 8-33 жилийн хугацаанд тухайн салбартаа ажилласан, гадаад, дотоодын төслүүдийг удирдахын зэрэгцээ, төсөлд оролцдог, судалгаа шинжилгээний ажил хийж, зөвлөгөө өгдөг байна.
- Тухайн салбарын нээлт, туршилт, судалгааг үйлдвэрлэлд нэвтрүүлж патент, зохиогчийн эрхийг эзэмшдэг

#### **Анхаарах асуудал:**

- Докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарт зориулсан тусгай хөтөлбөргүй

#### **Зөвлөмж:**

- Багш, төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах
- Багшлах боловсон хүчний ажиллах нөхцөлийг сайжруулах
- Багш нарыг тодорхой хугацаанд сургалтанд хамруулах, гадаад хэлний мэдлэгийг сайжруулах

#### **Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **4.2. Багшлахуйн үнэлгээ**

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол өгч, үр дүнг тооцдог.
- ХААИС-ийн багш нарыг 4-5 жил тутам аттестачилалд хамруулан хөндлөнгийн үнэлгээ өгдөг.
- Жил бүр бүрэлдэхүүн сургуулийн шилдэг сурган хүмүүжүүлэгч, шилдэг судлаач багш, шилдэг залуу багш гэсэн номинацаар багш болон тэнхимийг шалгаруулдаг.
- Оюутны сэтгэл хангамжийн судалгаа 3.7 оноо буюу сэтгэл ханамж өндөр байна.
- ХААИС-ийн багш, ажилчдын орон сууцны хангамжийг сайжруулах хөтөлбөртэй.

#### **Онцлог зүйл:**

- Багшийг ур чадвар, заах арга, хандлага, сургалтын орчин, оюутны сэтгэл ханамжийн байдлаар үнэлдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Доктор, магистрын хөтөлбөрт зааж байгаа хичээлийн үнэлгээний тогтолцоо нь багшийн хөгжлийг дэмжихгүй, бодитой үнэлэгдэхгүй байна.
- Багшийн цагийн ачаалал их байна.

#### **Зөвлөмж:**

- Багшийн эрдэм шинжилгээний үнэлгээг бодитой болгох, кредит цаг үнэлэх урамшуулал олгох
- Багш нар мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд өөрсдийн болон сургуулийн зүгээс үе шатлалтай арга хэмжээ авах, багш нарыг албан тушаалын зэрэглэлээ ахиулахад анхаарах хэрэгтэй.
- Урамшуулалын зарим системийг сайжруулах

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **4.3. Багшийн хөгжил**

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, докторын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инновац нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Монгол Улсын хэмжээнд 2019 оны 1-р сарын 01-нээс мөрдсөн “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль, 2016 оны 6-р сарын 27-ний өдрийн хууль, ХААИС-ийн ректорын 2002 оны 11-р сарын 20-ны өдрийн 156 тоот тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөрийн бодлогын баримт бичгийг ХААИС-ийн тэнхимийн эрхлэгчдийн 2017 оны 02-р сарын 23-ны өдрийн тушаалаар сайшааж, захиргааны зөвлөлийн 2017 оны 03-р сарын 23-ны өдрийн хурлаар батлагдсан баримт бичгийг ХААИС-ийн багшийн хөгжилд мөрддөг болсон.
- ХААИС нь 2017-2018 оны хичээлийн жилд шинээр багшийн хөгжил хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн дагуу LCE программ хангамжийг шинээр нэвтрүүлсэн байна
- Багшийн хөгжлийн хөтөлбөр

#### **Онцлог зүйл:**

- Ахисан түвшний оюутнуудад хичээл заадаг багш нарын сэтгэл ханамж, суралцагсдад ээлтэй орчин бүрдүүлэх, сургахуйн чадамжийг сайжруулах, үнэлгээ, хөтөлбөрийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох зорилгоор тогтмол судалгаа авч судалгааны үр дүнд анализ хийж ажиллах төлөвлөгөөтэй.
- Период систем нь багшийн хөгжлийг дэмжиж байсан.

#### **Анхаарах асуудал:**

- Сургуулийн төсвөөс хэдэн хувийг сүүлийн жилүүдэд багшийн хөгжилд төсөвлөн, зарцуулсан талаар анализ хийхэд санхүүгийн жилийн тайлан жилээр гарах учраас онцлон төсвийн хэдэн хувь нь эрдэм шинжилгээнд зарцуулсныг харуулсан тодорхой мэдээлэл байхгүй байна.
- МДС нь докторантын судалгааны ажлын үйл ажиллагаанд сургалтын төлбөрийн 5 хувийг зарцуулна гэж журманд тусгасан байдаг хэдий ч санхүүжилтийг шийдвэрлэдэггүй, зарцуулдаггүй дутагдалтай тал байдаг юм байна.

#### **Зөвлөмж:**

- Багшийн ажиллах нөхцөлийг сайжруулах (Ажлын өрөө, лаб, ариун цэврийн өрөө, халаалт)

- Ямар шалгуураар хэдэн жилийн хугацаанд профессор, дэд профессор албан тушаалд ажиллуулдаг дүрэм, журам, шалгуурыг сайжруулах

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **4.4. Судалгаа ба хөгжил**

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, докторантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ХААИС нь судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд оюутан бүр судлаач, профессор бүр мэдлэгийн менежер байх, профессор судлаач бүр өөрийнхөө судалгаан дээр суурилсан гарааны компани байгуулах зорилт тавин ажилладаг.
- Сүүлийн 3 жилд докторын эрэгтэй багшийн эзлэх хувь 20 хувиар өсөж, 55 хувь нь гадны хөгжилтэй оронд докторын зэргээ хамгаалсан.
- 2002, 2010, 2018 онд боловсруулсан багшийн хөгжил хөтөлбөр
- Сүүлийн 5 жилд патент 17, стандарт 11, төсөл 11, гэрээт болон ахиалгат ажил 10, IF-тай сэтгүүлд 7, олон улсын сэтгүүлд 12, дотоодын сэтгүүлд 36, сургуулийн хэмжээнд 14 өгүүлэл хэвлүүлсэн байна.

#### **Онцлог зүйл:**

- Агрономи мэргэжлийн докторын хөтөлбөрийн сургалт нь дадлагад илүү суурилсан байдаг учраас докторант оюутан бүр судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж, түүнийг үйлдвэрлэлд хэрэгжүүлэхэд багш нар хамтран ажилладаг.
- Сүүлийн жилүүдэд экологид ээлтэй газар тариаланг хөгжүүлэх, органик тариаланг хөгжүүлэх, ургамал хамгаалалын чиглэлээр Өмнөд Солонгос улсын КОЙКА, КОПИА-МОНГОЛ төв, Япон улсын ЖАЙКА ОУБ, Францын Жээрис ОУБ, АНУ-ын Глобал трайнинг центр, дотоодын БСШУЯамны ШУТсан, ХХААЯам болон бусад олон байгууллагуудтай хамтран олон улсын болон дотоодын захиалгат болон гэрээт төслийг хэрэгжүүлж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Багш нар судалгааны шинэ арга зүй боловсруулж ажиллахад сургалтын бааз, лабораторийн хангамж муу байна.
- Профессорын багийн үйл ажиллагааг кредитийн хөнгөлөлтөөс өөр дэмжлэг үзүүлэхгүй байгаа тул хөгжих боломж муу байна.
- Багшийн цагийн ачаалал их байдгаас хамаарч багш нар судалгааны ажилд цаг бага зарцуулдаг.
- Багш нарын ном, гарын авлагыг хэвлүүлэхэд сургуулийн зүгээс дэмжлэг муу үзүүлдэгээс хамаарч сурах бичгийн шинэчлэл муу хийгдэж байна.

#### **Зөвлөмж:**

- Судалгааны үр дүнгээр хянан магадалгаа хийгддэг гадаадын нэр хүндтэй сэтгүүлд ЭШ-ний өгүүлэл ажлыг идэвхжүүлэх

- Олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл хангалтгүй (5 жилд 5 өгүүлэл) байна. Судалгааны ажлын үр дүнг заавал олон улсын “Web of science”, “Scopus”-тай сэтгүүлд хэвлүүлэх талаар багш нарыг дэмжих хэрэгтэй.
- Байгалийн ухааны шинжлэх ухаан нь (ерөнхий биологи, молекул биологи, микробиологи, ухаалаг газар тариалан гэх мэт) цаг хугацаатай уралдаж хөгжиж байдаг. Иймээс англи хэл дээр хэвлэгдсэн, хамгийн сүүлийн үеийн сурах бичигтэй болох

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 5. НӨӨЦ БА САНХҮҮЖИЛТ**

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

#### **5.1. Сургалт, судалгааны орчин**

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр докторант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөрсний агрохимийн лаборатори
- Хөрсний микробиологийн лаборатори
- Ургамлын үржүүлгийн лаборатори
- Ургамлын үрийн экологийн лаборатори
- Ургамлын стресс физиологийн лаборатори
- Хээрийн сургалт судалгааны “Өнжин” бааз 36 га
- Хээрийн сургалт судалгааны “Нарт” бааз 266 га
- Лекцийн - өрөө
- Семинар дадлагын өрөө
- Оюутны хөгжлийн танхим
- Зоогийн “Оюутан зоог”
- Утасгүй интернетээр холбогдсон цахим банк
- “Хатан Туул”-театр
- Google classroom-платформ
- Докторын уншлагын танхим
- Диссертаци, Ном бүтээлийн булан

#### **Онцлог зүйл:**

- Практик дадлагын 3 бааз талбайтай
- Туршилт судалгаа явуулах орчин нөхцөл бүрдсэн

#### **Зөвлөмж:**

- Сургалтын болон судалгааны лабораторийг зааглах

- Сургалт судалгааны ажлын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах
- Лаборатори орчны материал арга зүй, ашиглалтын бүртгэл, тогтолцоог сайжруулах

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

## **5.2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн**

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, докторантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХАА-н эрдэм шинжилгээний бүтээлийн фонд
- Виртуал, дижитал видео, аудио цахим эх үүсвэр
- Номын сан 44122 нэр төрлийн номтой
- Интернет, WiFi,
- Lib4U Net Version
- Нээлттэй цахим сан-8:
- WWW. jstor.org; [www. bioone.org](http://www.bioone.org); www. oxfordreference.com; www. springeropen.com; www. oxfordmedicine.com
- Хэвлэх үйлчилгээ
- Магистр, докторын уншлагын тэнхим
- Зураасан кодын үйлчилгээтэй
- “Springer Nature”, “www. springerprotocols.com, www.link.springer.com”

### **Онцлог зүйл:**

- Сургалтад хэрэглэгдэх голлох ном бүтээл, сурах бичгийг багш нар өөрсдөө боловсруулан бүтээж, зохиогчийн эхийг авч хэрэглэж байна.

### **Анхаарах асуудал:**

- Нэмэлтээр авах нарийн мэргэжлийн ном, сурах бичиг, бүтээлийн хүрэлцээ хангамж, нэр төрлийг сайжруулах төлөвлөгөө, судалгаатай байх

### **Зөвлөмж:**

- Нарийн мэргэжлийн ном, сурах бичиг, бүтээлийн хүрэлцээ хангамж, нэр төрлийг сайжруулах
- Шинэчлэх, шинэ хэрэгцээ шаардлагатай олон улсын түвшинд нийтлэг сурах бичиг гарын авлагаар хөтөлбөрийг баяжуулах
- Англи сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх
- Ахиц бууралтын дүгнэлт, цаашид авах арга хэмжээг тодорхой болгох

### **Шаардлага:**

- Сургалтад олон улсад дагаж мөрдөж буй нийтлэг сургалтын хэрэглэгдэхүүнийг нэвтрүүлэх
- Гадаад хэл дээрх эх сурвалжийг түлхүү ашиглах

**Шалгуурыг хангасан байдал:** Хэсэгчлэн хангасан



### **5.3. Төсөв, санхүүжилт**

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулдаг, үүнд багш нарын саналыг харгалздаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн сургалтын журмын - 7-р бүлэгт “Суралцагчийг урамшуулах, тэтгэлэг олгох” тусгайлсан заалт
- Сургалтын төлбөрийг тооцох загвар
- Нэг суралцагчид ноогдох шууд зардал 89.4 % шууд бус зардал 12.2%
- Хөтөлбөрийн докторын төлбөр 1 кредит- 120000 ₮
- Тус хөтөлбөрт ХААИС-ийн багш нар хөнгөлттэй үнээр суралцах
- Профессорын баг ажиллах журмын 5.2-т Профессорын багт ЭШ ажлын төсвөөс 10 хувийг олгох тухай тусгасан
- ХААИС-иас судалгааны төсөл санхүүжүүлэх журам
- ХААИС-ийн 2019 оны төсөвт 3.9 хувийг ЭШ, судалгааны ажил, төсөл, ШУТсан гэж хуваарилсан.

#### **Онцлог зүйл:**

- Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд лаб, орчны тоног төхөөрөмж материаллаг бааз сайжруулж ирсэн.
- Лаборатори захиалгат ажлуудыг хийж, санхүүжилтийн бусад эх үүсвэрийг бий болгодог.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хөгжүүлэлтэнд зориулж олон эх үүсвэрээс орж байгаа санхүүжилтийн хэдэн хувь нь багшлахуй, суралцахуйн орчинд зарцуулагдаж буй хувь хэмжээ, цаашдын төлөвлөлт тодорхойгүй байгаад анхаарах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр өөрийгөө хэрхэн санхүүжүүлж байгаа тухай тусгайлсан судалгаа гаргаж цаашид дүгнэлт хийн ажиллах
- Багш нарыг мэргэжлийн болон мэргэшүүлэх чиглэлээр гадаад дотоодын сургалтанд хамруулах
- Багшлах залгамж халааг бэлтгэхэд онцгойлон анхаарах
- Дадлагын баазыг механикжуулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх, дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэхэд анхаарах
- Багшлах чадавх, гадаад хэлний мэдлэгийг сайжруулах сургалтанд хөнгөлөлт, дэмжлэг дорвитой үзүүлэх

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 6. УДИРДЛАГА БА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоотой, захиргааны зохистой бүтэц, удирдлагын мэдээллийн системтэй байна.

### 6.1. Засаглал ба удирдлага

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.

#### Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн магистр докторын сургууль (1997-2022)
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2019-2028
- Стратегийн 8 зорилт
- Сургуулийн засаглал, менежментийн чадавхийг бэхжүүлэх 6 зорилт үйл ажиллагаа
- Магистр, докторын сургалт эрхлэх журам - 2022-07/05
- Докторын зөвлөл хамгаалуулах зөвлөл- 2021-А/344 (15 хүн)
- Удирдлагын тогтолцоо: Эрдмийн зөвлөл, Захирал, Захиргааны зөвлөлөөс бүрдэх ба Чанарын удирдлага, зохицуулалтын алба, Эрдэм шинжилгээ, сургалтын бодлого зохицуулалтын болон эдийн засаг, хөгжлийн албадтай.
- Багшийн мэргэжлийн ёс зүйн нийтлэг дүрэм
- ЭШ-ний үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам
- Агрономийн хөтөлбөрийн хороо- ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн -2021-А/16
- Докторын сургалтын ганцаарчилсан төлөвлөгөө, маягт 16
- Багш нарын өөрийн үнэлгээний тайлан, 2022 он.
- Хичээлийн хөтөлбөрт 6 хичээл шинэчилж, өөрчлөлт оруулсан.
- Цахим хичээлүүдийг сайжруулсан. Зарим оюутнууд гадаад, хөдөө байх тохиолдолд цахимаар хичээл ордог.
- Хөтөлбөрийн төлөвлөгөө , хэрхэн үнэлж дүгнэсэн тодорхой биш байна.
- Хөтөлбөрийн сурталчилгаа: журмаа сайжруулж байгаа,

#### Онцлог зүйл:

- Удирдлага мэдээллийн ONEMIS, Eliademy программ нэвтрүүлсэн.

#### Анхаарах асуудал:

- Багш, судлаачдын ёс зүйн асуудлыг шийдвэрлэх тогтолцоо тодорхой бус.

#### Зөвлөмж:

- Өргөдөл гомдол, санал хүсэлт шийдвэрлүүлэх тогтолцоо нээлттэй ил тод биш байгааг УМИ болон бусад эх сурвалжаар суралцагч багш нарт тодорхой болгох.
- Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүний ёс зүйн зөвлөлтэй байх.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

### 6.2. Ажилтнууд

Захиргааны болон туслах ажилтны орон тоо хангалттай, зохих ур чадвар, туршлагатай байна. Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Магистр докторын сургуулийн туслах 2 ажилтантай, Магистр зэрэгтэй

**Онцлог зүйл:**

- Ахисан түвшний сургалтын санхүүгийн хөнгөлөлт эдлэх тогтолцоотой.

**Анхаарах асуудал:**

- Захиргааны туслах ажилтны тоо хангалтгүй.

**Зөвлөмж:**

- Захиргааны болон туслах ажилтны орчин үеийн дэвшилтэд мэдээллийн технологи эзэмших чадавхийг сайжруулах

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан**6.3. Удирдлагын мэдээллийн систем**

Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн бүтэц зохион байгуулалтын систем
- УМИ emuls.edu.mn
- Багшийн веб
- Дүрэм журмын эмхэтгэл
- Сэтгэл ханамжийн болон бусад судалгааны платформ, Үүнд:
- Сургалтын алба
- Хүний нөөц
- Сургалтын төлбөр г.м.
- Онлайн тестийн дэд систем
- Номын сангийн программ
- Эрдэм шинжилгээний систем
- Тайлангийн нэгдсэн систем
- Оюутны веб
- Багшийн веб
- Оюутны болон багшийн программ

**Онцлог зүйл:**

- Нээлттэй, ил тод удирдлагын мэдээллийн системтэй

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг сайжруулахад урт ба богино хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт үнэлгээнд хийх дүгнэлтийг сайжруулах, цаашдын арга замуудыг тодорхой болгох

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **6.4. Мэдээллийн ил тод байдал**

Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцагчийн үнэлгээний аргачлал зэрэг мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МДС-ийн [graduate.muls.edu.mn](http://graduate.muls.edu.mn):
- Бидний тухай, Элсэлт, Сургалт, Эрдэм шинжилгээ, Гадаад харилцаа, Дүрэм журам, Холбоо барих цэсүүдтэй
- <https://muls.lib4u.net/>
- Шинээр элсэгчдэд зориулсан гарын авлага
- <https://www.facebook.com/group/454077664989176>

#### **Онцлог зүйл:**

- МДС-ийн вэб сайт, фэйсвоок хуудасны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцсан мэдээлэл технологийн ажилтан байхгүй боловч СА-ны мэргэжилтэн нь нэгжээс ирсэн мэдээллийг түгээх, шинэчлэх зэрэг үйл ажиллагааг хариуцан ажилладаг.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг сурталчлах, сургалт мэдээллийн тогтолцоог сайжруулах

#### **Шаардлага:**

- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдал, түүнд мэдээллийн технологийн хөгжлийг ашиглах тогтолцоог сайжруулах
- Хөтөлбөрийн шинэчлэл, судалгаа, үр дүнг олон нийтэд мэдээлэх, хөтөлбөрийн оролцогч талуудын мэдээллийн нээлттэй ил тод байдлын боломжийг нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн мэргэжлийн ач холбогдол, давуу талыг нийтэд таниулах, ил тод байдлыг хангах

#### **Шалгуурыг хангасан байдал:** Хэсэгчлэн хангасан

**6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

#### **7.1. Дотоод чанарын баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөлтийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талуудын оролцдог байна.

### **Илрэл нотолгоо:**

- Чанарын удирдлага зохицуулалтын албатай
- Магистр, докторын хөтөлбөрөөр суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа 2017-2018
- Магистр, докторын хөтөлбөрөөр суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа 2016-2018
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа 2017-2018
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан 2016-2019
- Сэтгэл ханамжийн судалгаа 2018-2019
- Чанарын албаны холбогдох тайлан, хавтас
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2022
- ХААИС-ийн сургалтын чанарын удирдлага хяналтын удирдамж
- Хөтөлбөрийн хорооны нэг гишүүн чанарын баталгаажуулалт, сэтгэл ханамжийн судалгаа хариуцсан.
- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд 2019 оны 12 сард хуралдаж үйл ажиллагаагаа сайжруулалт төлөвлөлт хийсэн хурлын тэмдэглэл
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа 2020-2021

### **Онцлог зүйл:**

- Агрономч мэргэжлээр төгсөгчдийн холбоо байхгүй ч Монголын агрономичдын холбооны үйл ажиллагааг дүйцүүлэн ойлгодог. Тус холбооноос тогтмол гаргадаг мэргэжлийн бүтээлтэй (ISBN 978-99978-4-555-2), монголын агрономичдыг давтан сургах, ахисан шатны давтан сургалын жилд бүр 2 удаа зохион байгуулдаг. Газар тариалангийн салбарын танин мэдэхүйн “Ургадаг алт” сэтгүүлийг эрхлэн гаргадаг.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шат, хяналт чанарын баталгаажилтын тогтолцоог сул

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хөгжилтөнд сэтгэл ханамжийн үр дүнгийн хэрэгжилтийн явцын үнэлгээнд бүх талын оролцоог хангах
- Чанарын дотоод баталгаажуулалтын ач холбогдол, үр нөлөөний ойлголтыг ЧУЗА-аас багш нарт өгч, оролцоог нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог мөрдүүлэх

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

## **7.2. Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл**

Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХААИС байгууллагын магадлан итгэмжлэл гэрчилгээ
- Бакалавр, магистрын магадлан итгэмжлэлийн гэрчилгээ

### **Зөвлөмж:**

- Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байх.
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэх

**Шаардлага:**

- Чанарын хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрэн хангаж хэрэгжүүлэх

**Шалгуурыг хангасан байдал:** Хэсэгчлэн хангасан

**7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:  
ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

**ДҮГНЭЛТ**

Шалгуур		Бүрэн хангасан ( 2 )	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга				Бүрэн хангасан
2	Докторын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт				Бүрэн хангасан
3	Докторантын суралцахуйн үнэлгээ, хөгжил				Бүрэн хангасан
4	Багшлах бүрэлдэхүүн				Бүрэн хангасан
5	Нөөц ба санхүүжилт		5.2		Бүрэн хангасан

6	Удирдлага ба мэдээллийн систем		6.4		Бүрэн хангасан
7	Чанарын баталгаажуулалт		7.2		Хэсэгчлэн хангасан
<b>Дүгнэлт</b>		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ХААИС-ийн Магистр, докторын сургуулийн “Агрономи” 081109 докторын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн Докторын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... /Б.Оюунцэцэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Б.Одгэрэл/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /О.Энхтуяа/

### НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийг орчин үеийн хөгжил, хэрэгцээ шаардлагатай нийцүүлэн сайжруулах (гадаад хэл, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих арга зүй).</li> <li>- Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль зүй, эдийн засгийн талын хичээлийг хөтөлбөрт тусгах</li> <li>- Докторантын эрдэм шинжилгээний багц цаг тооцох (өгүүлэл, семинар, илтгэл, судалгааны ажилд оролцсон байдал гэх мэт)</li> </ul>
Шалгуур 2.	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, ач холбогдолыг сонирхогч талуудад элсэлтийн мэргэжлийн</li> </ul>

<p>Докторын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт</p>	<p>сурталчилгааг нэмэгдүүлэх, сурталчлах, элсэлтийн тоог нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өөр мэргэжлээс элсэн суралцагчдын нэмэлт багц цагийн хөтөлбөрийг хөтөлбөрийн хороо, хэрэгжүүлэгч нэгж боловсруулан батлуулж мөрдөх</li> <li>- Суралцагчийн судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, оюуны өмчийн асуудлаар богино хугацааны семинар зохион байгуулах, дэмжин туслах, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж тогтмолжуулах</li> <li>- Удирдагч багшийг суралцагч үнэлэх хуудас, удирдагч докторантыг үнэлэх хуудсаар жил бүр тогтмол явцын болон зөвлөн туслах ажлын тайланг гаргаж үнэлгээ хийж байх, МДС-ийн үйл ажиллагааг энэ чиглэлд идэвхжүүлэх</li> </ul>
<p>Шалгуур 3. Докторантын суралцахуйн үнэлгээ, хөгжил</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нэг хичээл тус бүрт тусгагдсан шалгалтын арга зүй хуучинсаг, тест, ярилцалага гэх хэлбэртэй байгааг анхаарч, суралцагчид үнэлгээний арга зүйг тохируулан шинэчлэх</li> <li>- Хичээл дүйцүүлэлт, үнэлгээний тогтолцоог эргэн харах</li> <li>- Оюутан солилцооны зохицуулалтыг оруулах, солилцооны хөтөлбөрийг докторантуудад чиглүүлэх</li> <li>- Оюутны хөгжлийн хөтөлбөр-докторантуудын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг бодитой үр дүнтэй болгож докторантуудад чиглүүлэх</li> <li>- Гадаад, дотоод оюутнуудаас сургалтын төлбөрийн талаар сэтгэл ханамжийн харьцуулсан судалгааг хөтөлбөр болон МДС авч дүгнэн үйл ажиллагаандаа тусгах</li> </ul>
<p>Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Багшийн цагийн ноогдолд докторын хөтөлбөрт зааж байгаа цагийг багтааж оруулах</li> <li>- Багшийн эрдэм шинжилгээний бүтээлүүдийн түвшинг нарийн гаргаж, ялангуяа гадны сэтгүүлд хэвлүүлсэн (Q1, Q2, Q3, Q4) багшийн бүтээлийг үнэлдэг журмыг сайжруулах, тодорхой болгох</li> </ul>
<p>Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалт судалгааны дотоод орчны ялангуяа зарим лабораторийн болон багш нарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах</li> <li>- Лаборатори орчинд сууж ажиллах хугацаанд ашиглах материалын нөөцийн бүртгэл, техникийн гарын авлага, ашиглах арга зүй, ашиглалтын бүртгэл зэргийг хөтлөх, мөрдөх, тогтолцоог сайжруулах</li> </ul>
<p>Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийг сайжруулахад урт ба богино хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт үнэлгээнд хийх дүгнэлтийг сайжруулах, цаашдын арга замуудыг тодорхой болгох</li> </ul>



Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	- Хөтөлбөрийн чанарын удирдлага, хяналтын системийн тогтолцоог шинэчлэн сайжруулах
<b>Шалгуур</b>	<b>Шаардлага</b>
5.2	- Сургалтад олон улсад дагаж мөрдөж буй нийтлэг сургалтын хэрэглэгдэхүүнийг нэвтрүүлэх - Гадаад хэл дээрх эх сурвалжийг түлхүү ашиглах
6.4	- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдал, түүнд мэдээллийн технологийн хөгжлийг ашиглах тогтолцоог сайжруулах - Хөтөлбөрийн шинэчлэл, судалгаа, үр дүнг олон нийтэд мэдээлэх, хөтөлбөрийн оролцогч талуудын мэдээллийн нээлттэй ил тод байдлын боломжийг нэмэгдүүлэх
7.2	- Чанарын хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрэн хангаж хэрэгжүүлэх

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

Суралцагчдын нэрс

№	Нэрс	Элссэн он	Сэдэв
1	Ш.Оюунчимэг	2017	Chenopodium зарим зүйлийн стресс тэсвэрлэх чадвар ба хүнд металл адсорбцлах чадвар
2	Г.Мөнхжин	2017	Таримал сагадын сорт судалгаа, агротехникийн судалгаа

3	Ш.Шинэбаяр	2019	Арвайн сорт сорилт, агротехникийн зарим асуудлууд
4	Б.Төртулга	2021	Агро-ойн зурвасын бичил уур амьсгал, буудайн ургац болон хөрсний үржил шимийн үзүүлэлтэнд үзүүлэх нөлөө
5	Б.Булган	2019	Газар тариалангийн Төв бүсийн нөхцөлд мөгөөрсхэй хонхорцгоныг ургуулах боломж, түүн дэх стеройдын агууламжийг судлах
6	А.Хасуншэт	2021	Алтайн бүсэд ээж будааны сортыг харьцуулан судлах
7	Г.Ганболор	2021	Гоодаль цэцгийн биометрийн ургалтад бордооны үзүүлэх нөлөө
8	О.Амгаланбаатар	2018	Алтайн бүсийн нөхцөлд жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх боломж

#### Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Оюунсүвд	ХХААХҮЯам	ХБУХ-ын хэлтсийн дарга
2	Баярсүх	УГТХ	Захирал
3	Дэжидмаа	МАНЭШХ	ЭША
4	Мөнхцэцэг	УХЭШХ	ЭНБдарга
5	Алтансүх	Дорнодын хүрээлэн	Захирал
6	Балжинням	Увсын хүрээлэн	Захирал

#### Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Д.Онон	2021	“Энх ногоон тал”ХХК	Дэд захирал
2	С.Дэнсмаа	2019	ХСИС	чанарын менежер
3	С.Оюун-Эрдэнэ	2021	УГТХүрээлэн	Судлаач

4	Э.Дорилогсүрэн	2020	УГТХүрээлэн	Судлаач
5	Энхтуяа	2021	ДБСЭШХүрээлэн	Судлаач
6	Б.Баяр-Эрдэнэ	2020	ХААИС	Төвийн эрхлэгч


#### Уулзалтанд оролцсон багш нарын мэдээлэл

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилла сан жил	Заадаг хичээл
1	Б.Амарсанаа	Хөтөлбөрийн зохицуулагч	Доктор (Sc), дэд профессор	25	Хөрсний үржил шимийн менежмент, Дээд агрохими
2	О.Мөнхжаргал	Профессор	Доктор (Sc), профессор	35	Агрозкосистемийн тогтвортой байдал, Усалгаатай тариалангийн менежмент
3	Л.Даваа	Дэд профессор	Доктор, дэд профессор	35	Хөрс боловсруулалтын технологи
4	Д.Ундармаа	Дэд профессор	Доктор, дэд профессор	26	Ургамлын хөнөөлт организмын эрсдлийн шинжилгээ
5	Ж.Очир	Ахлах багш	Доктор	32	-
6	Ж.Оюунгэрэл	Дэд профессор	Доктор, дэд профессор	26	Жимс ногооны дэвшилтэд технологи
7	З.Эрдэнэчимэг	Ахлах багш	Доктор	21	Таримал ургамлын селекц үрийн аж ахуй
8	О.Отгонцэцэг	Ахлах багш	Доктор	20	-

9	Д.Хандсүрэн	Дэд профессор	Доктор, дэд профессор	27	Жимс ногооны дэвшилтэд технологи
---	-------------	---------------	-----------------------	----	----------------------------------

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



**ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ  
АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ**


17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
11 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 243  
И-мэйл: agroecology@mul.edu.mn  
Вэб сайт: www.muls.edu.mn

2023.01.25 № 01/28  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

Агрономийн докторын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх шинжээчийн баг 7 шалгуур бүрээр шинжилгээ хийж зөвлөмж, шаардлага бүхий тайлан ирүүлснийг хүлээн авч танилцлаа.

Шинжээчийн тайланг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд өгсөн зөвлөмж, шаардлагын дагуу цаашид хөтөлбөрөө сайжруулан ажиллах болно. Тус хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үргэлжлүүлэн явуулж өгнө үү.

ЗАХИРАЛ  А.БУЯНБААТАР  
**023705015**